

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын статистикийн бодлого, төлөвлөлт, өгөгдлийн шинжилгээ, мэдээллийн сангийн
зохицуулалт хариуцсан шинжээч, Цэдвээ Батбаяр

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Гүйцэтгэлийн зорилт №1.2. Боловсролын салбарын 2024-2025 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулж цаасан болон цахим хэлбэрээр олон нийтэд сурталчилна.							
1	Боловсролын салбарын 2024-2025 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулж цаасан болон цахим хэлбэрээр олон нийтэд сурталчилна.	Эмхэтгэлийн тоо	Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2023-2024 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулан нийт 1500 ширхэгийг хэвлэж, нийтэд тархаасан.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2024-2025 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулан нийт 300 ширхэгийг хэвлэж, нийтэд тархаасан байна.	Боловсролын салбарын 2024–2025 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэлийг боловсруулж, нийт 136 хуудастай тайлангаар олон нийтэд хүргэлээ. Тайланг боловсруулах явцад БШУЯ-ны газар, хэлтсүүдийн санал, зөвлөмжийг тусган, сүүлийн дөрвөн жилийн динамик мэдээлэлд тулгуурлан	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					боловсруулсан бөгөөд салбарын хөгжлийн төлөв байдлыг бодитоор үнэлж, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор дараах онцлог ажлууд тусгасан. Үүнд: •Нийт 7 бүлэг бүхий бүтэцтэй тайланг боловсруулж, салбарын үндсэн 2500 орчим үзүүлэлтээр баяжуулсан; •Бүлэг бүрт сүүлийн 4 жилийн статистик динамикийг ашиглан салбарын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудал, эрэлт хэрэгцээг тодорхойлсон; •2030 он хүртэлх хэтийн төлөвийг тухайн үзүүлэлтүүдийн суурь мэдээлэлд үндэслэн тооцоолж тусгасан; •Статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд хялбар ойлгомжтой хэлбэрээр хүргэх зорилгоор инфографик		
--	--	--	--	--	--	--	--

					зураглалуудыг өргөнөөр ашигласан; •Салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн шалгуур үзүүлэлтүүдийг тайланд тооцон оруулсан. Тус эмхэтгэл нь боловсролын салбарын төлөвлөлт, бодлого боловсруулах, хэрэгжилтийг хянах, шийдвэр гаргахад чухал суурь баримт бичиг болохоор ач холбогдолтой юм. Хавсралт: 2 файл		
1.1. Гүйцэтгэлийн зорилт №1.3. Боловсролын салбарын 2025-2026 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.							
2	СӨББ -ын 2025-2026 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.	Албан ёсны статистикийн мэдээний тоо	Боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээллийг батлагдсан маягт, аргачлалын дагуу нэгтгэн, хянаж, боловсруулан үр дүнг батлагдсан хугацаанд нь холбогдох байгууллагад	Хаврын албан ёсны статистикийн мэдээг нэгтгэн хянаж, боловсруулан батлагдсан хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлж, нийтэд тархаах.	Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 08 сарын 30-ны өдрийн А/137 тоот тушаалаар батлагдсан маягтаар сургуулийн өмнөх боловсролын 1410, ерөнхий боловсролын 871, мэргэжлийн болон техникийн боловсролын 76, дээд боловсролын 64 сургалтын байгууллагын 2024	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн

			хүргүүлэх бэлтгэл ажлыг хангах		оны төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлага, хөрөнгийн албан ёсны статистикийн мэдээг БСМС-ээр дамжуулан хүлээн авах, хянах ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж, батлагдсан 16 маягт бүхий захиргааны статистик тайланг хянаж, нэгтгэн ҮСХ-д хугацаанд нь хүргүүлсэн. Хавсралт: 1 файл		байдал: 100%
--	--	--	--------------------------------	--	--	--	--------------

1.3. Гүйцэтгэлийн зорилт №1.4. Боловсролын салбарын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах

3	ЕБС, СӨБ-ын сургалтын байгууллагын статистикийн мэдээ, тайлан, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, мэдээллээр хангах.	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын тоо	2024 оны 08 сарын 23-24-ний өдрүүдэд 21 аймаг, 9 дүүрэг, нийслэлийн нийт 64 мэргэжилтэнд статистикийн мэдээллийн чанар, хугацааны талаар мэдээлэл хүргэх сургалтыг амжилттай зохион байгуулсан.	Боловсролын салбарын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдээс чадавхжуулах сургалтын чиглэлээр санал авах.	2025 онд зохион байгуулагдах чадавхжуулах сургалтын хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн боловсролын салбарын статистикийн мэдээллийн систем хариуцсан нийт 64 мэргэжилтнээс санал авсан. Санал авах үйл ажиллагаа нь тухайн мэргэжилтнүүдийн хэрэгцээ, тулгамдаж буй асуудал, сургалтын чиглэл, хэлбэрийг	6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	--	---	--	--	-------------------------------------	--

					тодорхойлох зорилготой бөгөөд энэхүү саналд үндэслэн “Боловсролын төлөөх даян дэлхийн түншлэл” олон улсын байгууллагын санхүүжилттэй “Системийн чадавхыг бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төслийн хүрээнд чадавхжуулах сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Сургалтын үндсэн зорилго нь боловсролын статистикийн мэдээллийн системийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, статистикийн мэдээллийг боловсруулалт, дүн шинжилгээ хийх чадавхыг сайжруулах, улс, орон нутгийн түвшинд нотолгоонд суурилсан төлөвлөлт, бодлогын шийдвэр гаргалтыг дэмжихэд оршино. Тус		
--	--	--	--	--	--	--	--

					сургалтын агуулга, арга зүйг олон улсын зөвлөмж, орон нутгийн хэрэгцээнд тулгуурлан боловсруулж, 2025 оны турш шат дараатайгаар зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.		
1.4. Гүйцэтгэлийн зорилт №1.5. Боловсролын салбарын мэдээллийн системийн баяжуулалт, лавлагааны сангийн бүрдүүлэлт хийнэ.							
4	СӨБ болон ЕБС-ийн цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанар, лавлагаа, тодорхойлолтын санг нэмэгдүүлнэ.	Лавлагааны санг баяжуулсан тоо, Цахимаар үйлчилгээ үзүүлсэн тоо, Нэмэгдсэн үйлчилгээний тоо	2023-2024 оны хичээлийн жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 151,917, ЕБС-д суралцаж буй 776,876, СӨБ суралцаж буй 275,25, НТБТ-д суралцаж буй 5,127 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 417,850 иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж E-Mongolia системийн санд орсон байна.	Лавлагаа тодорхойлолтын сан 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээллээр баяжсан байна.	Улсын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд боловсролын сургалтын байгууллага сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрт бүртгэлтэй 1253,9 мянган суралцагч, 111,6 мянган багш, ажилчдын мэдээллийн Боловсролын салбарын мэдээллийн системд шинэчилж баталгаажуулсан. Хавсралт: 4 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

3.1. Гүйцэтгэлийн зорилт №3.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарын шалгуур үзүүлэлтийг тооцох, үр дүнг хугацаанд нь тайлагнах

5	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Төлөвлөгөө, тайлангийн тоо	ТАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулан, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тухай бүр боловсруулан, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.	Албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилт арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, 2024 онд Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, Байгууллагын шуурхай, хурал, цуглаан, мэдээллийн цагт идэвхтэй оролцсон байна	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан бөгөөд хугацаанд нь хэрэгжүүлэн, явцыг сар, улирлаар тайлагнан ажиллаж байна. Мөн Боловсролын сайдын 2025 оны "Боловсролын сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах тухай" 03 дугаар албан даалгавар-ын хэрэгжилтийн хүрээнд гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт болон асуулга авах үйл ажиллагааг цахимаар зохион байгуулахтай холбоотойгоор шаардлагатай тоног төхөөрөмж, сүлжээний дэд бүтцийн бэлэн байдлыг хангах үйл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	----------------------------	--	--	--	--	--

					ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/90 дүгээр тушаалаар байгуулсан бөгөөд уг ажлын хэсэгт ажиллаж, нийслэлийн ерөнхий боловсролын 1, 2, 5, 21, 23, 24, 84 дүгээр сургуулиудын шалгалтын явцтай танилцан, шалгалтын явц, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, газар дээр нь үнэлгээ хийж ажиллалаа. 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Боловсролын сайдын 2024 оны А/260 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хавсралт: 1 файл		
6	Архив, албан хэрэг	Ирсэн бичгийн	2024 оны жилийн	-	ТЖАХ-ийн	1-р сар,	Өөрийн

хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, албан бичгийг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	шийдвэрлэлтийн хувь, архивд хүлээлгэн өгсөн материалын тоо	эцэст нийт 35 албан бичиг ирснийг зохих журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн.		гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ болон Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд 2024 оны статистик тайлан, ирсэн бичиг баримтаар архивын 4 хавтас бүрдүүлэн хүлээлгэн өгсөн.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	---	--	---	--	---

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7

1	Боловсролын салбарын статистикийн чиглэлээр гадаад, дотоод сургалтад хамрагдах	Мэргэжил чадвараа дээшлүүлэх ур	Ахлах түшмэлийн багц сургалтад хамрагдсан.	Боловсролын салбарын хөгжлийн чиглэлээр мэдлэг, чадвараа дээшлүүлж, чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдсан байна.	Боловсролын салбарын өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор сургалтын байгууллагын дэд бүтэц, хүний нөөц, багшлах боловсон хүчний хүрэлцээ, сурагчдын сурлагын амжилт, элсэлт, төгсөлт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт гэсэн хүрээний дагуу боловсролын салбарын өгөгдлийг үүсгэх, шинжлэх, нэгтгэх үйл явцыг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр сургалтад 2025 оны 04 сарын 16, 17 -ны өдрүүдэд “Боловсролын салбарын аналитик дашбоардуудыг ашиглах, хэрэглэх” сэдэвт сургалтад хамрагдсан Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Албан тушаалын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбоотой шинээр гарсан хууль тогтоомж, журмыг бие даан судалж, хэрэгжилтийг хангаж ажиллах.	Албан тушаалын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбоотой шинээр гарсан хууль тогтоомж, журмыг бие даан судлах.	Боловсролын салбарын хөгжлийн чиглэлээр мэдлэг, чадвараа дээшлүүлэх, чадавх бэхжүүлэх сургалтад 5 удаа хамрагдсан.	Боловсролын салбарын шинээр гарсан хууль тогтоомж, журамтай танилцаж судалсан байна.	Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон Ерөнхий боловсролын тухай хуулиудыг судлах ажлын хүрээнд боловсролын салбарын статистикийн захиргааны маягтыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын статистикийн бодлого, төлөвлөлт, өгөгдлийн шинжилгээ, мэдээллийн сангийн зохицуулалт хариуцсан шинжээч, Цэдвээ Батбаяр /...../ Огноо: